



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2012 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 1211

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг үндэслэн их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Монгол улсын их сургуулийн багш Чагнаадорж овогтой Оюунцэндийг Шинэ Зеланд Улсын Массеи их сургуулийн докторантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 3 жилийн, Монгол улсын их сургуулийн багш Ганбаатар овогтой Баасанжавыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Шпайерын удирдлагын их сургуулийн докторантурт Төрийн удирдлагын чиглэлээр 3 жилийн, Ховд их сургуулийн багш Мандах овогтой Оюунчимэгийг Япон Улсын Киото их сургуулийн докторантурт Хэл шинжлэлийн чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР